

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>	
Тайлагнах хугацаа	2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 06-р сарын 30-ны өдөр
<p><i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i></p>	<p>Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Дотоод: gobi.mn Гадаад: gobicashmere.com</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Амарсайхан /Гүйцэтгэх захирал/
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

1.1.	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД		
	НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
		<i>(мян.төг)</i>	
		2023.12.31	2024.06.30
	ХӨРӨНГӨ		
	<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,491,111	4,690,765
	Дансны ба бусад авлага	8,030,908	13,129,811
	Урьдчилгаа төлбөр	3,173,680	5,234,177
	Бараа материал	142,521,277	181,945,077
		163,216,976	204,999,830
	<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
	Үндсэн хөрөнгө	130,748,653	140,036,528
	Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	2,109,747	1,529,797
	Хойшлогдсон татварын хөрөнгө	9,276,559	8,647,496
	Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	6,431,599	5,123,483
		148,566,558	155,337,304
	Нийт хөрөнгийн дүн	311,783,533	360,337,134
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
	<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
	Дансны ба бусад өглөг	38,880,126	38,808,373
	Гэрээний өр төлбөр	1,672,424	2,724,232
	Богино хугацаат түрээсийн өглөг	964,376	573,317
	Орлогын албан татварын өглөг	1,801,508	82,822
	Богино хугацаат зээл	232,559,514	270,973,779
		275,877,949	313,162,523
	<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
	Урт хугацаат түрээсийн өглөг	1,321,948	1,159,044
	Урт хугацаат зээл	9,830,059	48,687,120
	Бусад урт хугацаат өглөг	17,036,260	-
	Хойшлогдсон татварын өглөг	7,883,775	7,883,775
		36,072,042	57,729,939
	Нийт өр төлбөрийн дүн	311,949,990	370,892,461
	<i>Эзэмшигчдийн өмч</i>		
	Хувьцаат капитал	780,113	780,113
	Дахин үнэлгээний нэмэгдэл	44,568,540	44,568,540
	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(10,662,273)	(6,900,631)
	Хуримтлагдсан алдагдал	(34,852,837)	(49,003,349)
		(166,457)	(10,555,327)
	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	311,783,533	360,337,134

1.2.	<i>Орлогын тайлан</i>		
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН		
		<i>(мян.төг)</i>	
		2023.12.31	2024.06.30
	Борлуулалтын орлого	255,650,516	76,093,992
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(131,011,345)	(42,299,781)
	Нийт ашиг	124,639,171	33,794,211
	Бусад орлого	592,777	205,286
	Борлуулалт ба маркетингийн зардал	(73,593,361)	(20,886,765)
	Ерөнхий ба удирдлагын зардал	(19,733,240)	(11,214,978)
	Бусад зардал	(6,980)	-
	Санхүүгийн орлого	229,734	9,301
	Санхүүгийн зардал	(32,104,979)	(15,394,196)
	Татварын өмнөх алдагдал	23,123	(13,487,141)
	Орлогын татварын өгөөж (зардал)	(6,791,082)	(663,371)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	(6,767,959)	(14,150,512)
	Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
	Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	773,737	3,761,642
	Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй (алдагдал) орлого	773,737	3,761,642
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(5,994,221)	(10,388,870)

1.3.	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					<i>(мян.төг)</i>
	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын хөрвүүлэлти йн нөөц	Хуримтлагд сан ашиг (алдагдал)	Нийт	
	2023 оны 01 сарын 01- ний үлдэгдэл	780,113	44,568,540	(11,436,010)	(28,084,878)	5,827,765
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,767,959)	(6,767,959)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	773,737	-	773,737
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	773,737	(6,767,959)	(5,994,221)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	780,113	44,568,540	(10,662,273)	(34,852,837)	(166,457)
	Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(14,150,512)	(14,150,512)
	Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	3,761,642	-	3,761,642
	Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	3,761,642	(14,150,512)	(10,388,870)
	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
	2024 оны 06 сарын 30- ны үлдэгдэл	780,113	44,568,540	(6,900,631)	(49,003,349)	(10,555,327)
1.4.	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>					
	"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН					<i>(мян.төг)</i>
				2023.12.31	2024.06.30	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(19,005,294)	(62,783,503)	
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			(3,862,024)	(6,124,831)	
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ			23,307,356	64,250,537	
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ			440,039	(4,657,797)	
	Гадаад үйл ажиллагааг хөрвүүлсэн гадаад валютын ханшийн зөрүү			16,153	(142,549)	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			9,034,919	9,491,111	
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			9,491,111	4,690,765	

2.

Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт

GOBI



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг дүгнэх тухай 7

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг хэлэлцэж, олон нийтэд мэдээлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хагас жилийн тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга
Гишүүд



А.ЖАРГАЛМАА

Д.ГЭРЭЛМАА

Н.МӨНХБАТ

3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>																			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="671 367 1046 423">Үзүүлэлт</th> <th data-bbox="1046 367 1230 423">2023.06.30</th> <th data-bbox="1230 367 1422 423">2024.06.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="671 423 1046 472">Бохир ашгийн маржин</td> <td data-bbox="1046 423 1230 472">49%</td> <td data-bbox="1230 423 1422 472">44%</td> </tr> <tr> <td data-bbox="671 472 1046 521">Цэвэр ашгийн маржин</td> <td data-bbox="1046 472 1230 521">-12%</td> <td data-bbox="1230 472 1422 521">-19%</td> </tr> <tr> <td data-bbox="671 521 1046 571">Эргэлтийн харьцаа</td> <td data-bbox="1046 521 1230 571">0.9</td> <td data-bbox="1230 521 1422 571">0.7</td> </tr> <tr> <td data-bbox="671 571 1046 620">Бараа материалын эргэц</td> <td data-bbox="1046 571 1230 620">527</td> <td data-bbox="1230 571 1422 620">510</td> </tr> <tr> <td data-bbox="671 620 1046 669">Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td data-bbox="1046 620 1230 669">295</td> <td data-bbox="1230 620 1422 669">262</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2023.06.30	2024.06.30	Бохир ашгийн маржин	49%	44%	Цэвэр ашгийн маржин	-12%	-19%	Эргэлтийн харьцаа	0.9	0.7	Бараа материалын эргэц	527	510	Хувьцааны нэгж үнэ /₮/	295	262
Үзүүлэлт	2023.06.30	2024.06.30																		
Бохир ашгийн маржин	49%	44%																		
Цэвэр ашгийн маржин	-12%	-19%																		
Эргэлтийн харьцаа	0.9	0.7																		
Бараа материалын эргэц	527	510																		
Хувьцааны нэгж үнэ /₮/	295	262																		
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>																			
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<ul style="list-style-type: none"> • Дотоодын зах зээлийн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 8%-аар өссөн. Бид хэрэглэгчдийн ая тухтай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэх, борлуулалтыг дэмжих зорилгоор үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүртээ засвар шинэчлэлийг хийсэн. • Гадаад зах зээлийн хувьд 2024 онд маркетингийн зардлаа бууруулж, илүү брэндинг-д чиглэсэн маркетинг хийхээр төлөвлөж байна. Маркетингийн зардлын бууралт нь борлуулалтын орлогод шууд нөлөө үзүүлж орлого буурахаар байгаа хэдий ч бид 2024 онд борлуулалтын өсөлтөөс илүү ашигт ажиллагааг сайжруулахад анхаарч байна. Үүнтэй холбоотой эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс маркетингийн зардлыг 69%-аар бууруулснаар борлуулалт 63%-аар буурсан ч алдагдлын хэмжээг өнгөрсөн оны мөн үеэс 41%-аар бууруулж чадсан. • Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийж компанийн өнгө төрхөө шинэчилсэн. • Бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн 100% ноолууран малгайг хөгжүүлэлт хийн 2024 оны 1-р улиралд худалдаанд гаргасан бөгөөд шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн болох Vulcanized Ултай Sneakers болон ноолууран Ballerina–г 2024 оны 2-р улиралд худалдаанд гаргав. Ноолууран Ballerina нь амьсгалдаг технологиор бүтээсэн тул хөлийг халууцуулахгүй агаарыг бүрэн нэвтрүүлэх боломжтойгоороо онцлог тул хэрэглэгчдийн таашаалд өндрөөр нийцэж байна. Мөн шинэ төрлийн бүтээгдэхүүн болох ноолууран цүнхний хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна. • Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. • Сүлжмэл болон оёмолын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, үйлдвэрлэл дундын чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тухайн цаг үеийн өгөгдөл мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны хяналт удирдлага зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор INA MES системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн. 																		

3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																												
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																													
<p>ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй.</p> <p>СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ</p> <p>Говь ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 11-р сарын 20-ны №36 тоот тогтоолоор “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг баталсан. Тус журмын дагуу жил бүрийн эхэнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах хэлцэл хийхийг зөвшөөрсөн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт болон хэлцлийн төсвийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар баталдаг.</p> <p>Дээрх журмын дагуу батлагдсан жагсаалтад ороогүй этгээдтэй хийх болон батлагдсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх бүрд тухайлсан тогтоолоор ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн зөвшөөрөл олгодог.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь Компанийн хэмжээнд хийгдэж буй сонирхлын зөрчилтэй хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнэ нөхцөлөөр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаараа дамжуулан тогтмол хяналт тавьж ажилладаг.</p> <p>ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ</p> <p style="text-align: right;">(мян.төг)</p> <table border="1" data-bbox="240 1258 1445 1648"> <thead> <tr> <th>Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ</th> <th>2023.06.30</th> <th>2024.06.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Холбоотой талд өгсөн санхүүжилт</td> <td>57,950,000</td> <td>329,554,048</td> </tr> <tr> <td>Холбоотой талаас авсан санхүүжилт</td> <td>78,490,000</td> <td>345,297,000</td> </tr> <tr> <td>Холбоотой талтай хийсэн борлуулалт</td> <td>146,267</td> <td>81,044</td> </tr> <tr> <td>Холбоотой талаас авсан худалдан авалт</td> <td>1,126,822</td> <td>1,119,522</td> </tr> <tr> <td>Хүүгийн орлого</td> <td>195,185</td> <td>-</td> </tr> <tr> <td>Хүүгийн зардал</td> <td>1,442,510</td> <td>4,618,436</td> </tr> <tr> <td>Түрээсийн орлого</td> <td>128,081</td> <td>134,204</td> </tr> <tr> <td>Түрээсийн зардал</td> <td>686,371</td> <td>688,036</td> </tr> </tbody> </table> <p><i>Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно. Эдгээр холбоотой талуудтай компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг ТУЗ-ийн 2024 оны 01-р сарын 26-ны №03 тоот тогтоолоор олгосон болно.</i></p>				Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2023.06.30	2024.06.30	Холбоотой талд өгсөн санхүүжилт	57,950,000	329,554,048	Холбоотой талаас авсан санхүүжилт	78,490,000	345,297,000	Холбоотой талтай хийсэн борлуулалт	146,267	81,044	Холбоотой талаас авсан худалдан авалт	1,126,822	1,119,522	Хүүгийн орлого	195,185	-	Хүүгийн зардал	1,442,510	4,618,436	Түрээсийн орлого	128,081	134,204	Түрээсийн зардал	686,371	688,036
Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2023.06.30	2024.06.30																												
Холбоотой талд өгсөн санхүүжилт	57,950,000	329,554,048																												
Холбоотой талаас авсан санхүүжилт	78,490,000	345,297,000																												
Холбоотой талтай хийсэн борлуулалт	146,267	81,044																												
Холбоотой талаас авсан худалдан авалт	1,126,822	1,119,522																												
Хүүгийн орлого	195,185	-																												
Хүүгийн зардал	1,442,510	4,618,436																												
Түрээсийн орлого	128,081	134,204																												
Түрээсийн зардал	686,371	688,036																												
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл																													
Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.																														

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг сонгон томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог.

ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн ажлын алба ажилладаг бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулах, олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, засаглалын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, компанийн засаглалын асуудлыг хариуцах, хувьцаа эзэмшигч нарын санал хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх, мэдээ мэдээллээр хангах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2024 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт ХААН театр (Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж-25, Хаан банкны Сөүл оффисын 1 давхар)-т амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 12,462,706 (1.60%) саналын эрхтэй 629 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 678,761,381 (87.01%) саналын эрхтэй 74 хувьцаа эзэмшигч буюу нийт 691,224,087 саналын эрхтэй 703 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.61% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
3. ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
4. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
6. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсөв
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.


1. ТУЗ-өөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалинг шинэчлэн тогтоох саналыг 99.99%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн гишүүдийг 3 хараат бус гишүүн, 6 ердийн гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатай томилов.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан.

2024 оны 05-р сарын 02-ны өдөр ХЭХ-ын материал (110 хуудас хэвлэмэл материал 1 багц, 1 ном, 2 цахим хэлбэрийн материал)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



Таван Богд Холдингс ХХК

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

24,340

/2024.07.01-ний байдлаар/

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2023.12.31		2024.03.31		2024.07.01	
	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Таван Богд Холдингс ХХК	400,140,072	51.29%	665,378,372	85.29%	681,267,736	87.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	-	-	-	-

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь 22 охин компани, 3 хөрөнгө оруулалттай компани, нийт 12,000 гаруй ажилтантайгаар бизнесийн 8 үндсэн чиглэлээр салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ГОВЬ ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУХАЙ

Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК нь 2024 оны 03-р сард хувьцаа эзэмшлийн хувиа нэмэгдүүлэн компанийн 85.29 хувийг эзэмшигч болсон. Компанийн тухай хууль (КТХ)-ийн 53.2-д заасны дагуу “Таван Богд Холдингс” ХХК-ийн хувьцааны эзэмшил 75 хувийг давсан тул Говь ХК-ийн бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг КТХ-ийн 53 болон 54-р зүйлд заасны дагуу хуулийн хугацаанд хэрэгжүүлэх үүрэг Говь ХК-д үүссэн тул манай компани нээлттэй хувьцаат компанийн хувьд хуульд заасан үүргээ хэрэгжүүлэн, бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг нь эдлүүлж, тэдний эрх ашгийг хангах зорилгоор ТУЗ-ийн 2024 оны 04-р сарын 19-ний хурлаар “Бусад хувьцаа эзэмшигчдийн Хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх” шийдвэр гаргасан.

Тус шийдвэртэй холбоотой хувьцаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 06-р сарын 05-ны өдрийг дуустал цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авсан.

Дээрх хугацаанд нийт 96 хувьцаа эзэмшигчээс 3,427,017 ширхэг хувьцааг худалдах хүсэлт хүлээн авсан бөгөөд төлбөрийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд нь байршуулсан болно.

Шаардах эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлсэн тухай тайланг бэлтгэн 2024 оны 06-р сарын 13-ны өдөр СЗХ, МХБ-д хүргэсэн.

ТАВАН БОГД ХОЛДИНГС ХХК ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ДЭЭР ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАСАН ТУХАЙ

Таван Богд Холдингс ХХК нь Говь ХК-ийн хувь эзэмшлээ нэмэгдүүлсэнтэй холбоотой КТХ-ийн 57-р зүйлийн 57.1-д заасны дагуу үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр бусад хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авах саналыг 2024 оны 05-р сарын 27-ны өдрөөс 06-р сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргасан.

Тус хугацаанд Говь ХК-ийн нийт 12,462,347 ширхэг хувьцааг худалдах санал хүлээн авсны дагуу төлбөрийг 2024 оны 07-р сарын 01-ний өдөр бүрэн шилжүүлж, үүргээ биелүүлсэн.

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТ

ТУЗ-ийн 2024 оны 02-р сарын 28-ны өдрийн [№08 тоот](#) тогтоолоор Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайханыг 2024 оны 02-р сарын 29-ний өдрөөр дуусгавар болгон өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлж, 2024 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Б.Амарсайханыг томилохоор шийдвэрлэсэн.

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян.төг)

№	Зардлын төрөл	2023.06.30	2024.06.30	Өөрчлөлт %
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	20,545	23,830	16%
2	ТУЗ-ийн цалин			
2.1	Үндсэн цалин	72,400	78,600	9%
2.2	Оролцооны цалин	16,050	23,400	46%
2.3	Урамшуулалт цалин	-	-	
2.4	НДШ	11,415	13,739	20%
	Дүн	99,865	115,739	16%

3	Менежмент багийн удирдлагуудын цалин								
3.1	Үндсэн цалин	783,530	1,067,837	36%					
3.2	Урамшуулалт цалин	-	-						
3.3	НДШ	105,673	134,762	28%					
	Дүн	889,203	1,202,599	35%					
<i>Засаглалын бүтэц, үйл ажиллагаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.</i>									
7.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i>								
ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ									
	Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Эчнээ санал хураалт	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
	ТУЗ-ийн хурал	3	6	5	37	28	7	5	26
	Эрсдэл, аудитын хорооны хурал	1	-	2	7	2	1	2	1
	Нэр дэвшүүлэх хорооны хурал	1	-	3	14	8	7	9	3
	Цалин урамшууллын хорооны хурал	1	-	-	8	6	4	4	1
	Нийт	6	6	10	66	44	19	20	31
Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 оны эхний хагас жилд нийт 6 ээлжит хурал, 6 ээлжит бус хурал, 10 эчнээ санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллав.									
ТУЗ-ИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭР									
Тайлант хугацаанд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нийт 66 асуудлыг хэлэлцэн, 44 шийдвэр гаргаж, 31 тогтоолыг баталсан. Үүнд:									
<ul style="list-style-type: none"> • ТУЗ-өөс 26 тогтоол (дотоод үйл ажиллагаатай холбоотой 17 тогтоол, санхүүжилттэй холбоотой 8 тогтоол, үйл ажиллагаа өргөжүүлэх, хүний нөөцтэй холбоотой 1 тогтоол) • Эрсдэл, аудитын хорооноос 1 тогтоол, • Нэр дэвшүүлэх хорооноос 3 тогтоол, • Цалин, урамшууллын хорооноос 1 тогтоол. 									
Мөн чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 19 санал зөвлөмж, 20 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.									
НОГДОЛ АШИГ									
Говь ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01-р сарын 26-ны өдрийн №01 тоот тогтоолын дагуу компанийн 2023 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.									
МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ									
Хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.									
<ul style="list-style-type: none"> • 2023 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр); • 2023 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (монгол, англи хэл дээр); 									

- 2023 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан;
- 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлан;
- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан (2023.12.31-ний байдлаар);
- 2024 оны 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан;
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал;
- Шаардах эрх хэрэгжүүлсэн тухай тайлан.

ШИНЭЭР БАТЛАГДСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Говь ХК нь “Компанийн засаглалын кодексийн хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг 2022 оны 11-р сард баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 онд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг баталсан. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг 2024 оны 01-р сарын 22-ны Цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн баталсан.
- “Цалин, урамшууллын бодлого”-ыг шинэчлэн боловсруулан, Цалин урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн, 2024 оны 01-р сарын 26-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.

Засаглалтай холбоотой дэлгэрэнгүй тайлан мэдээлэлтэй Хавсралт дахь үйл ажиллагааны тайлангаас танилцана уу.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Амарсайхан

Овог, нэр:

Албан тушаал: “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Албан тушаал : “...” Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:


Огноо: 2024 оны 07-р сарын 19-ний өдөр



GOVI

**ГОВЬ ХК-ИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1.	КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	3
2.	САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	8
3.	2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БИД	19
4.	ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	30
5.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	43



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч “ГОВЬ” үйлдвэр нь 1981 онд байгуулагдаж эдүгээ 43 жил тасралтгүй үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа үндэсний томоохон үйлдвэрлэгч юм.

ГОВЬ ХК нь Монгол ямааны 100% ноолуураар хамгийн сүүлийн үеийн техник, технологиор үйлдвэрлэл явуулдаг ба үйлдвэрлэл, хүчин чадал, чанар, үйлчилгээ зэрэг бүх талын үзүүлэлтээрээ дэлхийн топ 5 ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн тоонд зүй ёсоор тооцогддог.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



204.7

тэрбум төгрөг

2024.06.30-ны байдлаар

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ



600 тонн
самнасан ноолуур



1,280 тонн ээрмэл утас
30 тонн нарийн ээрмэл
утас



1,650,000 ширхэг
сүлжмэл
бүтээгдэхүүн



640,000 ширхэг
нэхмэл
бүтээгдэхүүн



160,000 ширхэг
оёмол
бүтээгдэхүүн

Нийт **2,450,000** ширхэг бэлэн бүтээгдэхүүн



Бүтээгдэхүүний төрлөөс хамаарч **70-130** гаруй үйлдвэрлэлийн дамжлагаар дамжин, **300-500** орчим ажилбар хийгдэж бэлэн бүтээгдэхүүн бий болдог.



БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн дамжлага болон оёх, индүүдэх технологийг сурч, туршлага судлав.



Монгол-Солонгосын политехникийн коллежтэй "Говь Академи"-ийн хүрээнд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.



3-р сарын 1-ний өдөр Гүйцэтгэх захирлыг шинээр томилох ёслолын арга хэмжээ болж, Гүйцэтгэх захирлаар Б.Амарсайхан томилогдов.

GOBI  SAP S/4 HANA

SAP S/4 HANA ERP систем Co-Live болов.



UNIDO-ийн тэтгэлгээр Олон улсын "OEKO-TEX STANDARD 100" гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авав.



Азийн Хөгжлийн Банктай хамтран "Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл"-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.



Хөнгөн аж үйлдвэрийн 90 жилийн ойг угтсан нийт ажилтны баярын хурал зохион байгуулав.



Дотоод хяналтын лаборатори нь итгэмжлэгдсэн сорилтын лаборатори болов.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4-р сарын 29-ний өдөр зохион байгуулж, компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнгийн тайлан, ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, ТУЗ-ийн 2024 оны төсөв болон ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг шинээр сонгон томилж.



Дэлхийн №1 дэвшилтэт технологи бүхий Итали улсын "BIGAGLI" мөлхөө ээрэх машиныг амжилттай суурилуулж ээрмэлийн үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэв.

Ингэснээр сүлжмэл утас үйлдвэрлэл 50%-аар, нийт утас үйлдвэрлэл 20%-аар тус тус нэмэгдэн жилд 1,300 тонн утас үйлдвэрлэх боломжтой болов.




"Flagship Store" буюу төв дэлгүүр өнгө төрхөө шинэчлэн нээлтээ хийв. Шинэчлэгдсэн төв дэлгүүрийн албан ёсны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нээлтэнд хүрэлцэн ирсэн зочид үйлдвэрээр аялан түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн бий болох үйл явцтай танилцлаа. Өөр нэгэн онцлох үйл явдал нь үйлдвэр дотор зохион байгуулагдсан загварын шоу байсан ба уг шоугаар 2024 оны хавар зуны шинэ коллекц болон "Наадам" коллекцийн загваруудаас толилуулав.



Говь ХК нь Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Нэгдсэн удирдлагын тогтолцооны ISO 14001:2015, ISO 45001:2018, ISO 9001:2015 стандартуудын шалгуурыг бүрэн хангаж гэрчилгээгээ гурав дахь жилдээ амжилттай баталгаажуулав.




Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding-ийг оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд 7-р сарын 2-ны өдөр GOBI брэндийн бэлгэ тэмдэг, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхийг танилцуулав.



САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/



ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2023.06.30	2024.06.30			
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Өмнөх оноос өөрчлөлт		
				тоо	хувь	
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	83,523	76,094	(7,429)	-9%	
Дотоод борлуулалт	сая.төг	49,289	52,999	3,709	8%	
Экспорт борлуулалт	сая.төг	17,315	16,822	(492)	-3%	
Гадаад борлуулалт	сая.төг	16,918	6,273	(10,646)	-63%	
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	мян.ширхэг	351	308	(43)	-12%	
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	42,747	42,300	(447)	-1%	
НИЙТ АШИГ	сая.төг	40,775	33,794	(6,981)	-17%	
Нийт ашгийн хувь	хувь	49%	44%		-4%	
Үйл ажиллагааны зардал	сая.төг	49,493	47,209	(2,284)	-5%	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	(8,718)	(13,415)	(4,697)	-54%	
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	-10%	-18%		-7%	
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	1,098	72	(1,026)	-93%	
Татварын өмнөх ашиг	сая.төг	(9,816)	(13,487)	(3,671)	-37%	
ЦЭВЭР АШИГ	сая.төг	(9,974)	(14,151)	(4,177)	-42%	
Цэвэр ашгийн хувь	хувь	-12%	-19%		-7%	
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	92,241	89,509	(2,732)	-3%	
ҮЙЛДВЭРЛЭЛ	мян.ширхэг	505	531	26	5%	
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	369	343	(26)	-7%	
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ширхэг	119	172	53	44%	
Оёмол бүтээгдэхүүн	мян.ширхэг	17	16	(1)	-7%	
Пальто	мян.ширхэг	8	8	(0)	-2%	
Пиджак	мян.ширхэг	3	3	0	17%	
Ээрмэл утас	тонн	127	112	(15)	-12%	
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	1,574	1,723	149	9%	
Нэг ажилтанд ногдох орлого	сая.төг	53,064	44,164	(8,900)	-17%	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	2,543	15,594	13,051	513%	
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	360,969	370,892	9,923	3%	
Банкны зээл	сая.төг	287,025	312,873	25,848	9%	
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	358,852	360,337	1,485	0%	
Бараа материал	сая.төг	183,042	181,945	(1,097)	-1%	
МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	сая.төг	8,979	3,229	(5,750)	-64%	
Үүнээс: Гадаад маркетинг	сая.төг	8,136	2,502	(5,634)	-69%	


Санхүүжүүлэгчийн нэр	Валют	Жилийн хүү (%)	Дуусах хугацаа	2023.12.31		2024.06.30	
				Эцсийн үлдэгдэл (мян.валют)	Зээлийн үлдэгдэл (мян.төг)	Эцсийн үлдэгдэл (мян.валют)	Зээлийн үлдэгдэл (мян.төг)
Банкны зээл							
Голомт банк (Урт хугацаат зээл)	MNT	11.00%	2025	-	13,333,333	-	8,123,764
Голомт банк (Зээлийн шугам)	MNT	15.60%	2026	-	48,950,000	-	37,930,000
	USD	11.05%	2026	-	-	1,121	3,791,418
Голомт банк (Богино хугацаат зээл)	MNT	5.00%	2025	-	-	-	9,500,000
Хаан банк (Зээлийн шугам)	MNT	12.60%	2025	-	6,500,000	-	5,600,000
	USD	7.00%	2025	-	-	5,013	16,949,204
Хаан банк (Урт хугацаат зээл)	MNT	3.00%	2024	-	4,202,775	-	-
Хаан банк (Богино хугацаат зээл)	MNT	5.00%	2024	-	10,000,000	-	-
Хас банк (Зээлийн шугам)	USD	9.75%	2026	-	-	\$ 11,840	40,031,632
Хас банк (Богино хугацаат зээл)	MNT	5.00%	2024	-	16,666,667	-	-
Хас банк (Богино хугацаат зээл)				-	-	-	10,000,000
Ариг банк (Богино хугацаат зээл)	MNT	5.00%	2024	-	14,500,000	-	-
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	3.89%+SOFR	2026	-	-	\$ 18,000	60,858,900
Азийн хөгжлийн банк (ADB)	USD	3.89%+SOFR	2026	\$ 12,000	40,928,280	\$ 12,000	40,572,600
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	4.25%	2027	€ 8,000	30,333,280	€ 8,000	28,914,720
Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (IIB)	EUR	5.25%	2027	€ 14,000	53,083,240	€ 14,000	50,600,760
Нийт /Банкны зээл/					238,497,575		312,872,998
Бондын санхүүжилт							
Бонд (Богино хугацаат зээл) *	USD	8.50%	2025	-	-	\$ 3,250	10,988,413
Нийт санхүүжилт					238,497,575		323,861,411

* Говь ХК нь “Говь Бонд 2” санхүүжилт татах ажлын хүрээнд 2024 оны 04-р сарын 23-ны өдөр эрх бүхий байгууллагын тогтоолоор хаалттай хүрээнд эргэлтийн хөрөнгө, дахин санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх зорилгоор 12 сарын хугацаатай, жилийн 8.5%-ийн купонтой 16,800,000 ам.долларын бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд 2024 оны 06-р сарын 30-ны өдрийн байдлаар 3,250,000 ам.долларын бондыг хөрөнгө оруулагчдаас татсан байна.

Монгол банкны ханш /төг/


	2023.12.31	2024.06.30
USD	3,410.69	3,381.05
EUR	3,791.66	3,614.34

БОРЛУУЛАЛТ
53.0
тэрбум төгрөг




2024 оны эхний хагас жилд дотоод зах зээл 53.0 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оны мөн үеэс 8% өсөлтийг үзүүлэв.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Дотоод зах зээлийн борлуулалтыг бүтцээр нь авч үзвэл жуулчдын борлуулалт 33%-ийг эзэлж байна. /2023 оны мөн үед 47% эзэлж байсан./

БОРЛУУЛАЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН /мян.шир/



Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхгийг нэр төрлөөр нь задалбал бүтээгдэхүүний нэр төрлийг хөгжүүлэн ноолууран гутлын шинэ загваруудыг хэрэглэгчдэд хүргэснээр гутлын борлуулалт 4292% өссөн үзүүлэлттэй байна.



Хими цэвэрлэгээ, нөхөн засвар хүлээн авах шинэ салбарыг И-Мартын Хан-Уул салбар дотор нээсэн.

2024.01



VIP хэрэглэгч нар, аялал жуулчлалын компаниудын удирдлагуудад FW24 коллекцийг танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.

2024.02



Коллекцийн танилцуулгын үеэр ирсэн санал хүсэлтүүд дээр үндэслэн дэлгүүр дээрх Styling, Window display, бүтээгдэхүүний өрөлтийг иж бүрэн лүүкээр бүрдүүлдэг болсон.

2024.02



Дэлгүүрүүдийн POS системийг шинэчлэн нэвтрүүлэв.

2024.03



Аялал жуулчлалын улирлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж хөтөч, жолооч, аялалын компаниудын төлөөлөл бүхий 217 зочинд хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулж мэдээлэл хүргэв.

2024.03



Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр /Flagship Store/-ийн үндсэн тасгийн засвар, шинэчлэлийг хийв.

2024.05



Flagship Store-ийн нээлтийн үйл ажиллагааг хийн, үйлдвэр дэх загварын шоуг зохион байгуулав.

2024.06



Үйлдвэрийг Flagship Store-той холбосон хүзүүвчийг хийн ашиглалтад оруулав.

2024.06

БОРЛУУЛАЛТ
16.8
тэрбум төгрөг

17.3



2023.06.30



2024.06.30

↓3%

2024 оны эхний хагас жилд экспортын зах зээл 31 харилцагчид бүтээгдэхүүнээ нийлүүлж, 16.8 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 3% бууралттай байсан ч бизнес төлөвлөгөөний биелэлт 105% байв.




2024 оны эхний хагас жилийн байдлаар **7** улсын **19** хотод **20** франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.



Экспортын борлуулалтын газраас үйлдвэр, үйлдвэр удирдлагын багтай хамтран үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх туршлага судлах зорилгоор БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрт ажиллаж БНСУ-ын сүлжмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн дамжлага болон оёх, индүүдэх технологийн туршлага хуримтлууллаа.

2024.01

БОРЛУУЛАЛТ
6.3
тэрбум төгрөг



Гадаад зах зээлийн хувьд 2024 онд маркетингийн зардлаа бууруулж, илүү брэндинг-д чиглэсэн маркетинг хийн борлуулалтын өсөлтөөс илүү ашигт ажиллагааг сайжруулахад анхаарч байна. Үүнтэй холбоотой эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс маркетингийн зардлыг 69%-аар бууруулснаар борлуулалт 63%-аар буурсан ч алдагдлын хэмжээг өнгөрсөн оны мөн үеэс 41%-аар бууруулж чадсан.

ГОВЬ БРЭНДИЙН ОРГАНИК ХАЙЛТ (SEO)

Хугацаа	Түлхүүр үгийн байр				Нийт түлхүүр үгийн тоо	
	1-3		4-10			
2024.06.30	1,030	172%	2,257	100%	14,825	41%
2023.06.30	379		1,129		10,525	

Гадаад борлуулалтын зах зээлд 2023 оноос эхлэн SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхааран үе шаттай арга хэмжээг аван ажиллаж байна.

GOBI | NP digital

NPDI Agency-тэй хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд шинэ түлхүүр үгсийн судалгааг хамтран хийж, хэрэгжүүлж эхэлсэн.



Веб бүр дээр SEO сайжруулах 10+ блог оруулсан. Блог оруулснаар, веб рүү орж ирэх органик хандалт өссөн.

2024.01

2024.01-06

NPDI x GOBI ХАМТЫН АЖИЛЛАГАА

60,000+

Characters бүхий text хэлбэрийн контент шинээр оруулсан

100+

Task-ууд болон засваруудыг вебсайт дээр оруулсан

30+

Онлайн уулзалт, хурлуудыг зохион байгуулсан

Нейл Пателийг Уолл Стрит сэтгүүл, Форбс болон НҮБ-аас хүлээн зөвшөөрсөн ба дэлхийн хамгийн нөлөө бүхий, амжилттай маркетерууд, бизнес эрхлэгчдийн нэг гэдгээрээ алдартай.


+41.7%

Түлхүүр үгсийн тооны өсөлт.
Түүнчлэн бүх цаг үеийн хамгийн өндөр түлхүүр үгсийн тоондоо хүрсэн

+75.8%

Органик хандалтын өсөлт

Түлхүүр үгсийн тоо



GOBI | digital



2024 оны эхний хагас жилд хамтран ажилласан:

Инфлүэнсэр

PR: 80, Internal: 16,

Дижитал сэтгүүл

Rollacoaster: : 1,

Алдартан

VIP: 4

Сэтгүүл & Хэвлэл

Онлайн: 77 Хэвлэл: 4

Блог

14

Бусад

Press days /4.18-4.19/: 250 сэтгүүлч , алдартнуудыг хамарсан брэндийн танилцуулга өдөрлөг
Podcast: Konfekt Corner by Monocle Radio Chapter 4

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн


86.5%

 **@Asap12vy,**
391 мянган дагагчтай алдартан /АНУ/




 **@julienpicket,**
128 мянган дагагчтай инфлүэнсэр /АНУ/




 **@herstyleboard,**
672 мянган дагагчтай алдартан /ХБНГУ/



 **@laurengiraldo,**
1 сая дагагчтай инфлүэнсэр /АНУ/




 **@Pamelaandersson,**
3.4 сая дагагчтай алдартан /АНУ/



 **@rollacoaster,**
298 мянган дагагчтай дижитал сэтгүүл /Их Британи/






**2024 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
БИД**

ENTERPRISE RESOURCE MANAGEMENT (ERP) СИСТЕМ

Компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2023 оноос эхлүүлсэн бөгөөд 2024 оны 3-р сараас эхлэн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн.

Энэхүү системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Говь ХК-ийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, бэлэн бүтээгдэхүүний чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тогтвортой, хэвийн үйл ажиллагаа зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.




БИЗНЕС ПРОЦЕСС

Алба нэгж хэлтсүүдтэй хамтран уялдаатай, олон улсын жишгийн дагуу ажиллах. Бизнесийн процессоо сайжруулах, улмаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх



АЖЛЫН БҮТЭЭМЖ

Цаг хугацаа хожих, ажлын чанар болон бүтээмж сайжрах.



ШИЙДВЭР ГАРГАЛТ

Удирдлагын тайлан мэдээлэл үнэн зөв, датанд суурилсан шийдвэр гаргалт хийх. Мэдээ мэдээллийг хурдтай авах.



ХҮНИЙ ГАР АЖИЛЛАГАА

Ойлголтын зөрүү багасгах, ажлын түүх, залгамж халаа сайжрах. Хүний гар ажиллагааны алдаа багасгах.

MANUFACTURING EXECUTION SYSTEM (MES) СИСТЕМ

Говь ХК нь INA MES системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2024 оны 7 сараас эхлүүлсэн бөгөөд 2025 оны 1-р сараас эхлэн үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Говь ХК-ийн Сүлжмэл болон Оёмолын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, үйлдвэрлэл дундын чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тухайн цаг үеийн өгөгдөл мэдээлэл, хэвийн үйл ажиллагааны хяналт удирдлага зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.

01 Бараа материалын удирдлагын үйл ажиллагааны сайжруулалт хийх

02 Өгөгдөл дээр тулгуурласан шийдвэр гаргалт болон нөөцийн хуваарилалт хийх

03 Үйлдвэрлэлийн процессын бодит хяналт болон удирдлага

04 Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн мөшгилт болон чанарын хяналтыг хийх

05 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн бүтээмжийг нэмэгдүүлэх





GOBI & ORGANIC FW 24/25 Presentation

- Компани дотоод ажилчид
 - VIP үйлчлүүлэгч
 - Хувьцаа эзэмшигч
 - Аялал жуулчлалын компаниудын төлөөлөл
 - Харилцагч
- зэрэг нийт 107 зочидод 4 өдрийн 7 удаагийн танилцуулгыг хийсэн.

Үргэлжлүүлэн бид Giorgio Spina дизайнертай хамтран

- Cashmere Reborn
- Responsible Cashmere
- Gobi SS25
- Organic SS25 коллекц тус бүр дээр хөгжүүлэлт хийн ажиллаж байна.



2024 оны хагас жилд:

- Үндсэн **3**, капсул **12** коллекц болон
- Шинэ нэр төрлийн **5** бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ танилцуулав.

1-р улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



ЦАГААН САРЫН
КАПСУЛ КОЛЛЕКЦ



TRENDY COATS
КАПСУЛ КОЛЛЕКЦ



МАРТ 8
КАПСУЛ КОЛЛЕКЦ



LIGHT BEINGS SS24
ORGANIC КОЛЛЕКЦ



SPORT CASUAL
КАПСУЛ КОЛЛЕКЦ



ГОЁО FW 23
2-Р ХЭСЭГ



CASHMERE KNITTED
SNEAKERS
ШИНЭ ӨНГӨ



НООЛУУРАН
САРАВЧТАЙ МАЛГАЙ



“ДОМГИЙН АМЪТАД”
БАРЛАСАН ШААЛЬ



CASHMERE SNEAKERS
ШИНЭ ЗАГВАР

2-р улиралд хэрэглэгчдэд хүргэсэн коллекц, бүтээгдэхүүнүүд



MATERNITY
КАПСУЛ КОЛЛЕКЦ



RESPONSIBLE CASHMERE
КАПСУЛ КОЛЛЕКЦ



GOBI LIGHT BEINGS
SS25 КОЛЛЕКЦ



NEW BORN
КАПСУЛ КОЛЛЕКЦ



CASHMERE REBORN
КАПСУЛ КОЛЛЕКЦ



KIDS SS24
КОЛЛЕКЦ



ЗУРААЧИДТАЙ
ХАМТАРСАН
БҮТЭЭЛҮҮД



НООЛУУРАН
BALLERINA ГУТАЛ



ШИНЭ ТӨРЛИЙН
ХАТГАМАЛТАЙ
ПИДЖАК



НААДАМ 2024
КАПСУЛ КОЛЛЕКЦ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Runway

- Жуулчны улирал нээлт
- Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн баяр
- MONGOLIAN FASHION WEEK
- Flagship Store Grand Opening Runway Show

Styling

- Худалдаанд гарч буй шинэ коллекциуд
- Цуврал стилл бүрдүүлэлт видео контент



ОНЦЛОХ ЗАХИАЛГУУД




Ерөнхийлөгчийн тамгын газрын, хүндэтгэлийн захиалгуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс дурдвал:

- Бутаны Хаант Улсын Эзэн Хааны айлчлалтай холбоотой “Хааны гэр бүлд” бэлэг
- Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч А.Г.Лукашенкогийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламентын дарга Нурланбек Шакиевийн айлчлалын бэлэг
- Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгчийн бэлэг

ШИНЭЭР САНААЧИЛЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД, ҮР ДҮН



- 2023 онд 100% ноолууран малгайг хөгжүүлэлт хийж эхлэн 2024 оны 1 дүгээр улиралд худалдаанд гаргав.
- Whole garment 8L машинд тулгуурласан шинэ төрлийн зузаан оёдолгүй загварууд хөгжүүлэн худалдаанд анхлан гаргав.
- Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн болох Vulcanized Ултай Sneakers болон ноолууран Ballerina-г 2024 оны 2 дугаар улиралд худалдаанд гаргав. Ноолууран Ballerina нь амьсгалдаг технологиор бүтээсэн тул хөлийг халууцуулахгүй агаарыг бүрэн нэвтрүүлэх боломжтойгоороо онцлог тул хэрэглэгчдийн таашаалд өндрөөр нийцэж байна.
- Шинэ төрлийн бүтээгдэхүүн болох ноолууран цүнхний хөгжүүлэлтийг хийн ажиллаж байна.
- Gobi FW 24/25 коллекцид зориулан шинээр 3 төрлийн драп хөгжүүлэлт хийн гарган авсан.



6

Organic SS, Gobi SS,
Cashmere hat, Coat new
colors, Sport casual,
Whole Garment

КОЛЛЕКЦИ ЗУРАГ АВАЛТ

9

Lunar new year, Shawl,
Women's day,
Chinese 5/20, 6/18,
Summer Getaway

СТАНДАРТ ЗУРАГ АВАЛТ

14

Organic SS, GOBI SS,
Whole Garment,
Cashmere hat, Ballerina,
Basic Collection

ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН
ЗУРАГ АВАЛТ

2


Winter and Spring In
Mongolia

TRACEABILITY ЗУРАГ АВАЛТ

REBRANDING


GOBI

Олон улсын зах зээлд брэнд танигдалтаа нэмэгдүүлж, зах зээлээ тэлэх зорилготойгоор Rebranding хийх ажлыг 2024 оны эхнээс хийж эхэлсэн бөгөөд 7-р сарын 2-ны өдөр GOBI брэндийн шинэ өнгө төрхийг танилцуулж, логогоо шинэчилж, анх удаагаа брэндийн бэлгэ тэмдэгтэй болов.



GOBI-ийн шинэчлэгдсэн бэлгэ тэмдэг нь ноолууран бүтээгдэхүүн бий болох үйл явцын гол оролцогч талуудыг илтгэнэ.

Truly Mongolian.



ТОГТВОРТОЙ
ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА



“Шинэ ажилтны сургалт”-ын агуулгад тогтвортой хөгжлийн талаарх ойлголт сэдвийг нэмж, Тогтвортой хөгжлийн хэлтсээс 7 хоног бүр 2 удаа сургалт орж эхлэв.



Нийт компанийн хэмжээнд “Нэг удаагийн хэрэгслийн хэрэглээг халах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэн, байнгын хэрэгслүүд болон аяга таваг угаагч, ариутгагч, бусад шаардлагатай бүтээгдэхүүнийг 5 байршилд байршуулав.



Азийн Хөгжлийн Банктай “Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.



Хятадын хөдөө аж ахуйн олон улсын хамтын ажиллагааг дэмжих CAPIAC байгууллагаас Хятад улсын Бээжин хотноо зохион байгуулсан “Global Sustainable Natural Fibers” хуралд амжилттай оролцов.



Тогтвортой хөгжлийн зөвлөх үйлчилгээний хүрээнд SBC байгууллагатай хамтран “Тогтвортой хөгжил ба маркетинг”, PWC байгууллагатай хамтран “Олон улсын хуулийн чиг хандлага” сэдэвт сургалт зохион байгуулав.

БАЙГАЛЬ ОРЧИН



Байгууллагын үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийн тооцооллыг хамрах хүрээ - 1,2,3 болон бүтээгдэхүүний LCA түвшинд тооцоолох ажлыг RCS байгууллагатай хамтран хийж байна.



Үйлдвэрийн хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл хэрэгжүүлж эхлэв.



Говь ХК, Гоёо ХХК-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 5 жилээр батлуулав.



Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 5 жилээр авав.

НИЙГЭМ

"Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"



"Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-д хамрагдсан малчдаас татан авсан ноолуураар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Европын зах зээлд "Responsible Collection" нэрээр борлуулж эхлэв.



Төсөлд хамрагдсан малчдаас ямааны нас, хүйсээр ангилсан дээж авах ажлыг хийж гүйцэтгэв. Тухайн дээжийг лабораторийн аргаар чанарын шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах ажил хийгдэж байна.



Төсөлд хамрагдсан малчдын гараас шууд ноолуур худалдан авах ажлыг хоёр дахь жилдээ амжилттай хийж гүйцэтгэлээ. Ойролцоогоор 10 тонн ноолуур татан авалт хийснээр малчдын орлого нэмэгдэх үндэс суурь нь болж байна.



Малчдад зориулан "Жендерийн эрх тэгш байдал" сэдэвт сургалт зохион байгуулж, "Жендерийн хүчирхийлэл"-ийн талаарх зурагт хуудас тараав.

"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд түүхий эд бэлтгэн нийлүүлэгч хоршоодын төлөөлөлтэй "Тогтвортой түүхий эд" сэдэв дор уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд Хан-Уул дүүргийн 3-р хороонд "Говь ХК-ийн мэдээллийн самбар" байршуулж, иргэдэд ил тод, хүртээмжтэй мэдээлэл хүргэх боломжийг нээв.



"Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-ний хүрээнд Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэд оршин суугчдад "Говь ХК-ийн нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөллийг үнэлэх журам"-ын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүргэв.

УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



Говь ХК нь Олон улсын **"OEKO-TEX STANDARD 100"** гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авсан бөгөөд энэхүү стандарт нь Говь ХК-ийн бэлэн бүтээгдэхүүний гол материал болох ноолууран утас болон товч зэрэг бусад туслах материалууд **хүний эрүүл мэнд болон арьстай шууд хүрэлцэхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, харшил үүсгэхгүй** болохыг илтгэх юм.

Уг стандартын баталгаажуулалтыг Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй "Экспортыг дэмжих төсөл"-ийн хүрээнд UNIDO буюу НҮБ-ын ҮХБ-ын тэтгэлгээр, Швейцар улсын Цюрих хотод төвтэй OEKO-TEX® байгууллагын шалгуурыг бүрэн ханган гардан авлаа.



Манай компани Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Нэгдсэн удирдлагын тогтолцооны:

- ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт
- ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт
- ISO 9001:2025 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын шалгуурыг бүрэн хангаж, олон улсын SGS баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээг гардан авсан билээ.

Бид 2024 онд гурав дахь жилдээ амжилттайгаар магадлан гэрчилгээг амжилттай баталгаажууллаа.

НИЙЦЛИЙН УДИРДЛАГА

Эх сурвалж	Төрөл	Тоо	Шийдвэрлэсэн байдал
Шүгэл үлээх системээр-21; Бичгээр- 1; Бусад сувгаар-1;	Харилцааны зөрчил	8	4-Сануулга, зөвлөмж өгөв.
			2-Гомдол, мэдээлэлд шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.
			2-Нотлох баримт хангалтгүй гэж буцаасан.
	Хөдөлмөрийн харилцаатай холбоотой	4	1-Зөвлөмж, үүрэг даалгавар хүргэгдэв.
			3-Гомдол, мэдээлэлд шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.
	Санал хүсэлт	4	4-Холбогдох газар, хэлтэст мэдээлэл шилжүүлэн хүргэв.
	Ёс зүйн кодтой холбоотой	2	2-Зөвлөмж, шийдвэр хүргэгдэж хариу авч ажилласан.
	Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой	2	1-Зөвлөмж, ажил сайжруулах төлөвлөгөө хүргүүлэв.
			1-Шийдвэрлэгдсэн гомдолд давхардсан тул хаасан.
	Хувь хүний эрхэд халдах	1	1-Холбогдох газар нэгж, хүмүүст зөвлөмж хүргүүлэв.
Дотоод дүрэм, журам зөрчсөнтэй холбоотой	1	Гомдол, мэдээлэлд шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.	
Хүлээн авах шаардлага хангахгүй	1	Хаасан.	
Нийт		23	



"Шүгэл үлээх систем"-ийн 2023 оны тайлан веб сайтад байршиж "Ёс зүйн код"-ын хэрэгжилтийг ИЛ ТОД танилцуулж эхлэв.



Бодлого, журмын хэрэгжилтийг хянах, процессыг сайжруулах зорилгоор баримт бичгийн нийцлийн хяналтын ажлыг эхлүүлэв.



Шүгэл үлээх системийн 2023 оны тайлан болон гүйцэтгэлийг 5 үйлдвэрийн **727** ажилтан буюу нийт ажилтны **43%**-д танхимаар танилцуулав.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- Эрсдэлийн удирдлагын баг шинээр томилогдов.
- Нийт байгууллагын хэмжээнд **424** эрсдэлийг эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлтийн дагуу амжилттай удирдаж, хагас жилийн мониторингоор **289** эрсдэл үлдсэн ба нийт эрсдэлийн түвшин **7** онооноос **4** оноотой **ДУНД** түвшинд хүрч буурав.
- Хагас жилийн эрсдэлийн үнэлгээгээр шинээр **104** эрсдэл нэмэгдэж бүртгэгдсэнээр нийт **393** эрсдэлийн түвшин дундаж түвшин **7** оноотой болов. Цаашид эрсдэл удирдах төлөвлөлтүүдийг шинэчлэн эрсдэлүүдийн түвшинг бууруулахаар зорин ажиллана.
- Эхний хагас жилийн байдлаар нийт 2 удаагийн гэнэтийн эрсдэлийн үнэлгээ хийв. Тухайлбал "Animal welfare"-тай холбоотой гэнэтийн эрсдэлийн үнэлгээ хийж, жагсаал цуглааны үед мөрдөх зааварчилгааг батлуулан Герман дахь дэлгүүрийн ажилтнуудад хүргүүлэв. Мөн зудтай холбоотой түүхий эдийн хомсдолын эрсдэлийн үнэлгээ хийв.
- Эрсдэлийн удирдлага болон Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны менежментийн хувьд байгууллагын мэдлэг ойлголтыг сайжруулах сургалтуудыг хоёрдугаар хагас жилд зохион байгуулахаар төлөвлөж байна.
- Ёс зүйн нийцлийн эрсдэлд илүү нарийвчилсан шинжилгээ хийн, анхаарал хандуулан анхаарч ажиллаж байна.
- "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам"-ын танилцуулгыг нийт ажилтнуудад хүргэв. Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа /БТҮА/-ны 5 төлөвлөгөөг боловсруулах багуудын томилгоог хийн, багуудад БТҮА менежментийн талаар болон Говь ХК-ийн БТҮА бодлого, журмын танилцуулгыг хийв. Эдгээр төлөвлөгөө боловсруулах багууд нь 7 хоног бүр тогтсон цагт уулзалт хийж байна.

ЗОРИЛТ: ОСОЛ-О БАЙХ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИНГҮЙ БАЙЖ, АЖИЛТНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ, ЧАНАРЖУУЛАХ

Хугацаа алдсан гэмтлийн давтамж	Тохиолдлуудыг *1,000,000 Ажилласан хугацаа /цаг/	LTI-давтамж
	0*1,000,000/5,362,200 хүн/ц	0.0

Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан өдөр:	419өдөр /1,600 ажилтнаар/
Хугацаа алдсан гэмтэлгүй ажилласан цаг:	5,362,200 хүн/ц
Тоолж эхэлсэн огноо:	2023.05.12
Сүүлийн огноо:	2024.07.04

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ

Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль болон Хөдөлмөрийн сайдын а/173 тоот тушаалын дагуу ХЭМАБ-ын ерөнхий мэдлэгийн болон эрх олгох сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

Үүнд:

1. Нийт ажилтны ХАБЭА-н сургалт
2. Цахилгааны аюулгүй ажиллагааны сургалт
3. Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалт
4. Өндөр хэмийн ажлын аюулгүй ажиллагааны сургалт
5. Өргөх зөөх машин механизмын операторын сургалт
6. Химийн хорт бодистой харьцаж ажиллах ажилтны аюулгүй ажиллагааны сургалт
7. Даралтат сав түүнд залгасан шугам хоолойтой харьцаж ажиллах ажилтны аюулгүй ажиллагааны сургалт

2024 эхний хагас жилд давхардсан тоогоор **2,624** ажилтанд, **16,027 хүн/цаг** сургалт орсон.

Огноо	Сэдвэл/Тайлбар	Тусгай	Мөд
2024.05.10	Төрийн албан хаагчид зориулсан ХАБЭА-н мэдлэгийн сургалт	Монголын улсын төрийн алба	8:00-12:00
2024.05.15	Хүндийн ажиллагааны аюулгүй ажиллагааны сургалт	Монголын улсын төрийн алба	8:00-12:00
2024.05.20	Өндөр хэмийн ажлын аюулгүй ажиллагааны сургалт	Монголын улсын төрийн алба	8:00-12:00
2024.05.25	Хүндийн ажиллагааны аюулгүй ажиллагааны сургалт	Монголын улсын төрийн алба	8:00-12:00





Хачигт халдвараас урьдчилан сэргийлэх

Ноолуур татан авалтын үед ажилчдыг хачигт халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор АШУ, түүхий эдийн нярав, чанар баталгаажуулалт, жолооч, лабораторийн **23 ажилтныг** хачигны вакцинд хамруулав.



Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнтэй хамтын ажиллагаа

УАУТХ, ҮЭ-той хамтран 2024 онд эмчилгээ, сувилгаа шаардлагатай ажилтнуудаа эмийн бус эмчилгээнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх зорилгоор жил бүр **60 ажилтнаа** УБ рашаан сувилалд хэвтүүлэн сувилуулж байна.



Халуун орчинд ажилладаг ажилчидад эрдэс нөхөх бүтээгдэхүүний олголт

Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор 1 улиралд давхардсан тоогоор **334 ажилтанд 22,965 ш** эрдэс нөхөх бүтээгдэхүүн олгов.



Аюулгүй ажиллагааны аян

Жил бүр зохион байгуулагддаг ХЭМАБ аяныг 04.26-наас 05.17-ны өдрийн хооронд амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд “Ажлын аюулын дүн шинжилгээ”, “Safety share”, “Контент бүтээх тэмцээн”, “Чадварлаг хамт олон” уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулав.



Гамшгийн зарлан мэдээлэх дуут дохиогоор ажиллах

Улс даяар 2024 оны 3-р сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “Гамшгийн зарлан мэдээлэх дохиогоор ажиллах” дадлага сургуулилд Говь, Гоёо, Говийн багачууд цэцэрлэг, Хэнтий аймгийн салбар үйлдвэрийн ажилчид оролцлоо.



Ундны усны шинжилгээ

Ундны усны шинжилгээг **MNS 9000:2018** стандартад нийцүүлэн нийт **69** цэгт шинжилгээ хийлгэсэн бөгөөд шинжилгээний үр дүн нийт 95.6% нь унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.



Эрүүл мэндийн хугацаат үзлэг

2024 оны эрүүл мэндийн хугацаат үзлэгийг 2 ээлжээр хуваарилан хамруулахаар төлөвлөсөн. Эхний ээлжийн үзлэгийг **5-аас 6-р сарын** хооронд “Буянт-Оношлогоо” ХХК-тай хамтран нийт **540** ажилтныг хамруулан зохион байгууллаа.



Эрүүл мэндийн даатгалд ажилтнуудаа хамруулав

Ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг санал болгож давхардсан тоогоор 2486 ажилтанд мэдээлэл өгч танилцуулсан ба 511 ажилтан сайн дураар хамрагдсан.



Хэвийн бусын үзлэг

“Буянт-Оношлогоо” ХХК-тай хамтарсан Хэвийн бусын багажийн үзлэгт 110 ажилтан хамрагдах байснаас 91 ажилтан буюу 82.7%-тай үзлэгт хамрагдлаа. Хэвийн бусын багажийн үзлэгийн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээгээр ажлын байранд тохирсон 4 багц сонгов.

Нийт ажилтны тоо:



1,723

Байршлаар:



Монгол-1,710 (99.2%)



УБ хот 1,648
Дархан 3
Хэнтий 59



Олон улс-13 (1%)

АНУ 1
Европ 12

Удирдлагын баг:



Хүүхэд асрах чөлөөтэй ажилтан



322

Ажилтнуудын дундаж нас



35



ЭРЭГТЭЙ
541/31%
дундаж нас-32



ЭМЭГТЭЙ
1,182/69%
дундаж нас-37

2012

Generation Z 18-22



1997

Generation Y 23-38



1981

Generation X 39-54




1965

Baby Boomers 55-73



1946



ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ



Замын хөдөлгөөний түгжрэлээс сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 3 дахь жилдээ ажлын **уян хатан цагийн системийг** оффисын **+500 ажилтнуудад** хэрэгжүүлж байна.



Ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй сүлжмэл бүтээгдэхүүний **24 оёдолчныг богиносгосон цагаар** ажиллуулж байна.



Бид ажилтны бие, сэтгэл зүй, санхүүгийн эрүүл мэндийг дэмжих “Health at Gobi” бодлогын хүрээнд МИГ даатгал ХХК-тай хамтран эрүүл мэндийн даатгалд одоогийн байдлаар нийт ажилтнуудын 50 хувь буюу 637 ажилтнуудаа болон тэдний гэр бүлийг сайн дураар, хөнгөлөлттэй үнийн нөхцөлөөр давхар хамрууллаа.

Ингэснээр, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, хэвтэн эмчлүүлэх болон гэрээр эмчлүүлэх гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа энэхүү даатгалын үйлчилгээг ашиглан цаг алдалгүйгээр санхүүгийн асуудлаа шийдэж, болзошгүй эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болж байна.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

1 АЖИЛТАНД
НОГДОХ СУРГАЛТЫН
ХҮН ЦАГ



1.32 хүн/цаг

НИЙТ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН
ЗАРЦУУЛАЛТ



146.8 сая

СУРГАЛТЫН ТОО

66

СУРГАЛТАД ХАМРАГДСАН
АЖИЛТНЫ ТОО

777

Гадаад орны
сургалт

- 5 удаагийн сургалт
- 12 ажилтан
- Зардал: 25.9 сая төгрөг

Гаднын
байгууллагын
сургалт

- 18 удаагийн сургалт
- 100 ажилтан
- Зардал: 120.9 сая төгрөг

Дотоод
сургалт

- 43 удаагийн сургалт
- 665 ажилтан
- Зардал: 0 төгрөг

ИДЭВХЖҮҮЛЭЛТ БОЛОН ОЛОН НИЙТИЙН АЖЛУУД

3x3 САГСАН БӨМБӨГИЙН
ТӨРӨЛД АВАРГАА ТОДРУУЛЛАА



ЭЭРМЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЖИЛТНУУД ЯПОН УЛСЫГ
ЗОРИЛОО



ГАДААД БОРЛУУЛАЛТЫН ГАЗРЫН
13 ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД
ЗОРИУЛЖ ӨДӨРЛӨГ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА



2023 ОНЫ ШИЛДЭГҮҮД АЯЛАЛДАА
ГАРЛАА



ҮЙЛДВЭРТЭЙ
ТАНИЛЦАХ АЯЛЛУУД
ХИЙГДЛЭЭ



ТАВАН БОГД ГРУППИЙН CHAMPIONSHIP
2024 СПОРТ КОМПАНИЙН АРГА
ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"ГОВЬ"-ИЙН ГЭР БҮЛИЙН
ГИШҮҮН ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ
ХҮРТЛЭЭ



ДИЗАЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН
ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН
БАХАРХЛЫН ӨДӨР



ХУУЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖЛИЙН
БАХАРХАЛТ ӨДРИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА



ДИЗАЙН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН
21 ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД
ЗОРИУЛЖ ӨДӨРЛӨГ ЗОХИОН
БАЙГУУЛАГДЛАА



НЭГЖИЙН УДИРДЛАГУУДЫГ
ЧАДАВХЖУУЛАХ GOBI LEADERS
MEETING СУРГАЛТ УУЛЗАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАА



СПОРТ КОМПА-Д АМЖИЛТАЙ
ОРОЛЦСОН 50 АЖИЛТНЫГ
ХҮЛЭЭЖ АВЛАА



ТАВАН БОГД ГРУППИЙН УДИРДАХ
АЖИЛТНЫ ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН
ҮЕЭР ГОВЬ ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТАНИЛЦУУЛЛАА



СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН
27 ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД
ЗОРИУЛЖ ӨДӨРЛӨГ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА



СОЁЛЫН ЭЛЧ ХӨТӨЛБӨР

ЗОРИЛГО: Компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг нийт ажилтнуудын дэмжлэг оролцоонд тулгуурлан таниулж, байгууллагын соёлыг бэхжүүлэх.



2024 оны 03-р сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан нийт ажилтны хурлын үеэр **СОЁЛЫН ЭЛЧ** хөтөлбөрийг эхлүүлж, нийт ажилтнуудад албан ёсны мэдээлэл хүргэсэн.

ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:

2024.04.01 - 2024.12.31

WORK ETHIC

Ажлын байранд мөрдөх ёс зүйг нийт ажилтнуудад мөрдлөг болгож хэвшүүлж, байгууллагын соёлыг бэхжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор контент бэлтгэн танилцуулдаг болсон.

WORK ETHIC Соёлын элч хөтөлбөр

GOBI
HONGKONG COMPANY

Хурлын дэг

- MS Teams ашиглан хурлын хуваарийг оролцогч талуудад 1-2 өдрийн өмнө илгээсэн байх
- Хурлын хуваарь мэдэгдэжтэй өмнө MS Teams-н хурлын өрөөний цаг тоололт хэсэгт захиалга өгч баталгаажуулсан байх
- Оролцогч талууд ирсэн хурлын хуваарийн дагуу оролцох болонготой эсэхийг мэдэгдэж ассерт хийх
- Хурал эхлэхээс 3-5 минутын өмнө хуваа болох газар ирэх хэвд эрхэлж бэлэнчлэх ёзууныг мэдэж эссэн байх
- Тухайн хурлын тэмдэглэлийг MS Teams групп чатанд бичиж байх
- Хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврыг MS Teams Task үүсгэж хэрэгжилтийг хангаж байх
- Хурлын дундуур хүндэтгэн узах шалтгаангүй орж гаралгүй байх (Хүндэтгэвэр) тэрийг шийдвэр гаргаж өгөхөд зориулж
- Хурал эхлэхийн өмнө утасны дугаар хэлсэн байх

Excellence & Happiness

WORK ETHIC Соёлын элч хөтөлбөр

GOBI
HONGKONG COMPANY

И-мэйл бичих соёл


- To** хэсэгт тус и-мэйлийн зорилготой хүнийг (all mail) нвуулж байгаа тохиолдолд all@gobihongkong.com хэсгийг ашиглаж захиарна уу?
- CC хэсэгт хяналт тавих хүнийг
- Subject** хэсэгт и-мэйлийн гэрчлэлийг цөөн үгээр тодорхойлж бичиж
- И-мэйлийн агуулгын Font-Arial, Size-11 байх
- Шалтгаангүй мэдрэмжийг таних зөв цогцтой байлгахтай агуулгаа бичихэд анхаарах
- Урьдчилж сонгож "Meeting" эхэлсэн турмын н дараа шалтга <https://gobichess.com/> ашиглан шалтгаан байх
- Өөрт ирсэн и-мэйлд 24-48 цагийн дотор хариу өгөх
- Батлагдсан и-мэйл signature загварыг ашиглан signature-н мэдээлэл элч эсхэмтгэн өгөх
- Харгалт буюу Attachments-ээс эвс оруулсан эсэхийг дараа нэгтгэх
- И-мэйлээр байгууллагын нууц мэдээллийг илгээхэд тухайн мэдээллийн агуулгын байдлад хяналт тавих/нууц мэдээлэл агуулсан байгааг нууц мэйл болгосон байх
- Айвч бичгийн үг хэллэг ашиглах

Excellence & Happiness


4-Р CAP
"ХҮНДЭТГЭЛ"

5-Р CAP
"ШУДАРГА- ИЛ ТОД БАЙДАЛ"

6-Р CAP
"ГАЛ ЭРМЭЛЗЭЛ"



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



НИЙТ ГАРГАСАН
ХУВЬЦААНЫ ТОО

780,112,500

НИЙТ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

24,340

2024.07.01-ний байдлаар

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Хувьцаа эзэмшигчийн нэр	2023.12.31		2024.03.31		2024.07.01	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Холдингс ХХК	400,140,072	51.29%	665,378,372	85.29%	681,267,736	87.33%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	-	-	-	-

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани юм. Таван Богд Групп нь 22 охин компани, 3 хөрөнгө оруулалттай компани, нийт 12,000 гаруй ажилтантайгаар бизнесийн 8 үндсэн чиглэлээр салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын манлайлагч групп компани юм.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



**Дамбын
ГЭРЭЛМАА**

*ТУЗ-ийн дарга,
Эрсдэл, аудитын хорооны гишүүн,
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн*
СЭЗИС, Бизнес удирдлагын
тэнхимийн профессор



**Дамбийжавын
ХҮРЭЛБААТАР**

*Нэр дэвшүүлэх хорооны
дарга, Цалин урамшууллын
хорооны дарга*



**Алтангэрэлийн
ЖАРГАЛМАА**

*Эрсдэл, аудитын хорооны
гишүүн, Цалин урамшууллын
хорооны гишүүн*
GAPE, АССА ахлах багш,
хөтөлбөрийн удирдагч



**Цагаачийн
БААТАРСАЙХАН**

*Нэр дэвшүүлэх хорооны
гишүүн*

Таван Богд Группийн
Ерөнхийлөгч



**Нямаагийн
МӨНХБАТ**

*Эрсдэл, аудитын хорооны
гишүүн*

Таван Богд Холдингс ХХК-
ийн Санхүү удирдлага
хариуцсан захирал

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



**Дашдаваагийн
ХУЛАН**

Таван Богд Группийн
ТУЗ-ийн дарга



**Энхтөрийн
ПҮРЭВЛХАМ**

*Цалин, урамшууллын
хорооны гишүүн*

Таван Богд Холдингс ХХК-
ийн Дэд захирал



**Баатарсайханы
АМАРСАЙХАН**

Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал



**Цогтгэрэлийн
ОРГИЛБОЛД**

Говь ХК-ийн
Тэргүүн дэд захирал,
Говь Кашмер Европ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ГОЛ ӨӨРЧЛӨЛТ

Говь ХК-ийн 2024 оны Хувьцаа
эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн
гишүүдийг 3 жилийн хугацаатай
сонгон томилов.
/Н.Мөнхбат, Э.Пүрэвлхам гишүүд
шинээр сонгогдсон/

Эрсдэл, аудитын хороо

Чиг үүрэг:

- Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх,
- Дотоод хяналт, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх,
- Хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:

А.Жаргалмаа

Гишүүд: Д.Гэрэлмаа
Н.Мөнхбат

Нэр дэвшүүлэх хороо

Чиг үүрэг:

- Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах,
- ЭБАТ-уудын ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих,
- ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:

Д.Хүрэлбаатар

Гишүүд: Д.Гэрэлмаа
Ц.Баатарсайхан

Цалин урамшууллын хороо

Чиг үүрэг:

- ЭБАТ-уудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлон хэрэгжилтэд хяналт тавих,
- Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих.

Бүрэлдэхүүн:

Хорооны дарга:

Д.Хүрэлбаатар

Гишүүд: А.Жаргалмаа
Э.Пүрэвлхам



Тэргүүн дэд
захирал
/Гадаад,
экспорт
борлуулалт/

Ц.ОРГИЛБОЛД



Тэргүүн дэд
захирал
/Дотоод
борлуулалт/

Б.АРИУНАА



Санхүү
бүртгэл
хариуцсан
захирал

Д.СОДГЭРЭЛ



Хүний нөөц
хариуцсан
захирал

Д.СОЁЛМАА



Мэдээлэл
технологи
хариуцсан
захирал

Б.ЭРДЭНЭ



Нийцэл
хариуцсан
захирал

Б.ЧИНГҮҮН



Гүйцэтгэх
захирал

Б.АМАРСАЙХАН



Тэргүүн дэд
захирал
/Дизайн,
үйлдвэрлэл,
дэмжих/

Б.ЭНХМАНДАХ



Экспортын
борлуулалт
хариуцсан
захирал

Г.АНУДАРЬ



Хуулийн
хэлтсийн
дарга

Ц.ЦАСЧИХЭР



Дизайн,
үйлдвэрлэл
хариуцсан
дэд захирал

Б.БОЛОРМАА



Дизайн
хөгжүүлэлт
хариуцсан
захирал

А.УЧРАЛ



ТУЗ-ийн
нарийн
бичгийн
дарга

М.СЭЛЭНГЭ



Гадаад
борлуулалт
хариуцсан
дэд захирал

О.МИШЭЭЛ



Мерчендайзинг
хариуцсан
захирал

О.ЦЭНГЭЛ



Дотоод
аудитын
хэлтсийн дарга

Ц.УРАНЧИМЭГ


**МЕНЕЖМЕНТ БАГИЙН БҮТЦЭД ОРСОН
ГОЛ ӨӨРЧЛӨЛТ**

Говь ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор 2024 оны
03 сарын 01-ээс эхлэн Б.Амарсайханыг
Гүйцэтгэх захирлаар томилов.

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ **2024.06.30**-ны өдрийн хаалтын ханшаар **204.7** тэрбум төгрөг байна.

Нэгж хувьцааны дундаж ханш **264.85** төгрөг (▲ 0.4%)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.06.30	Өөрчлөлт %
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	273.59	262.34	-4.1%
Хамгийн их үнэ	350.00	283.98	-18.9%
Хамгийн бага үнэ	240.69	255.00	5.9%
Дундаж үнэ	263.90	264.85	0.4%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	7,500,000	257,495,975	3,333.3%
Хамгийн бага /өдөрт/	179	638	256.4%
Дундаж /өдөрт/	62,704	2,138,315	3,310.2%
Нийт	15,676,081	267,289,413	1,605.1%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	2,625,000,000	65,661,782,758	2,401.4%
Хамгийн бага /өдөрт/	52,805	168,698	219.5%
Дундаж /өдөрт/	18,985,172	545,392,131	2,772.7%
Нийт	4,746,292,927	68,174,016,399	1,336.4%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	213,430,978,875	204,654,713,250	-4.1%



№	Гарчиг	Авбал зохио оноо	2023.12.31-ний өдрийн байдлаар	
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.7%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100.0%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%
8	Компанийн соёл	6	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100.0%
Нэгдсэн дүн		72	70	97.2%

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ-ийн ажлын алба үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно.

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2023 оны эцсээр **97.2% буюу засаглал хэвийн, эрсдэлгүй** гэж үнэлэгдсэн байна. Энэхүү үзүүлэлтээрээ бид Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дундаас эхний байранд үнэлэгдсэн.

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай Монголын Хөрөнгийн Бирж болон компанийн цахим хуудаснаас, мөн [энд дарж](#) танилцах боломжтой.

2024 оны 06-р сард тус үнэлгээг шинэчлэн хийж Санхүүгийн зохицуулах хороо руу хүргэсэн бөгөөд хянан баталгаажуулалт хийгдсэний дараа олон нийтэд хүргэх болно.



GOBI

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА